

БАТЛАВ:

ДОРНОД АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА *Х.Баттулга* Х.БАТТУЛГА

“ОЙН НӨХӨРЛӨЛҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ”-ИЙН БАРИЛГЫГ  
БҮРЭН ДУУСГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2019.12.24

Баян-Уул сум

Зураг төсөв зохиох үндэслэл	-Монгол Улсын Ойн тухай тухай хууль -Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр. -Баян-Уул сумыг 2017-2020 онд хөгжүүлэх мөрийн хөтөлбөр -Баян-Уул сумын ойн сан нь Дорнод аймгийн ойн сангийн 70 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд 19 ойн нөхөрлөл үйл ажиллагаа явуулдаг. Тус нөхөрлөлүүдийг удирдлага мэдээллээр хангах үүрэг бүхий “Нөхөрлөлүүдийн холбоо” нь байгуулагдсан цагаасаа оффис буюу мэдээллийн төвийн байргүй үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд, 2019 онд аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас ойн мэдээллийн төвийн байр барихад дэмжлэг үзүүлж 25 сая төгрөгөөр барилгын гадна хийцийн барилга угсралтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2020 оны БОХНСЗардлаас нэмж 25 сая баталснаар уг барилгыг бүрэн дуусгаж ашиглалтанд өгөх.
Барилга, байгууламжийн байршил, чиглэл	Дорнод аймгийн Баян-Уул сум 4-р багийн нутаг дэвсгэрт “Төрийн банк”-ны баруун талд 0.07 га газарт
Захиалагч байгууллага:	Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар
Хөрөнгийн эх үүсвэр:	Аймгийн “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал”-ын хөрөнгө оруулалт
Ажлын зураг төсөв боловсруулахад ашиглах материал	Монгол улсын хуулиуд: -Барилгын тухай хууль Төсөл хөтөлбөрүүд: -Баян-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Норм, нормативууд: -Модон хийцийн барилгын олон улсад хүлээн зөвшөөрөгддөг ерөнхий стандартууд